

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 05 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд зэ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Ж.Батжаргал, Д.Батлут, Ц.Идэрбат, Н.Наранбаатар, Т.Энхтувшин нараас 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх мэдлийг өргөтгөн тэнцвэржүүлэх, бүтэц чиг үүргийн оновчтой бүрдүүлэх, тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн болон хорооны хэсгийн төлөөллийг хангах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чанартай хүргэж, орон нутгийн чухал шийдвэрүүд гарахад хугацаа алдахгүй байх, мөн Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдүүлнэ гэж үзэж хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим хаягт байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Хуулийн төсөлд иргэдийн Нийтийн Хуралд цахим болон технологийн бусад хэлбэрээр хуралдаанд оролцсоныг хурлын ирцэд оруулан тооцох, "... аймгийн төв, 20 мянгаас дээш хүн ам бүхий хот, суурин газрын иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд 50 өрх тутмаас" нэгээс доошгүй хүн хүрэлцэн ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцох, багийн Засаг даргад бүрэн дундаас дээш боловсролтой иргэнийг сонгох, баг, хорооны иргэдийн Нийтийн анхдугаар хуралдаанаас хуралдаан даргалагчийг 4 жилийн хугацаагаар сонгодог байхаар, хуралдааны даргад баг, хорооны Засаг даргын цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгохоор, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед авах шуурхай арга хэмжээний талаар, мөн нийтийн эрүүл мэнд, тээвэр, үндны ус, бэлчээрийн ашиглалт, хамгаалалт зэрэг хүн амын тулгамдсан асуудал болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас урьдчилан эрх олгосон бусад асуудлаар шийдвэр гаргаж, дараагийн хуралдаанд танилцуулах зэрэг зохицуулалтуудыг тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед асуулт асууж, үг хэлсэн гишүүн гараагүй болно.


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63.6 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



Н.ЭНХБОЛД